

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234704

ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН БИЧИХ ЧАДВАРЫГ
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Ч.Баттулга

Товч агуулга: Зохиогч уг өгүүлэлдээ, хүн аливаа зүйлийг бичихэд сэтгэц танин мэдэхүйн ямар үйл ажиллагаа явагддаг болон хүний бичсэн зүйл /Product writing/-ийг задлах, алдаа мэдгийг засахаас илүүтэй бичих үйл явц /Process writing/-ын талаас судлан шинжлэх, улмаар оюутан суралцагчдад энэ талын мэдлэг чадварыг эзэмшүүлэх юм. Мөн хэл бичгийн багш нар орчин үеийн бичих ур чадварын талаарх онол судалгаа, шаардлага, зөвлөмжтэй байнга танилцаж, оюутан суралцагчдыг бүгдийг бичгийн хүмүүс (эрдэмтэн, судлаач), зохиолч болгох маягийн заах арга барилаа өөрчлөх шаардлагатай болохыг дэвшүүлэв. Ингэснээр, дүн оноо авах гэсэн биш “Би бичих чадвар эзэмших ёстой”, “Бичих чадвартай болох нь надад маш чухал” гэсэн чин сэтгэл, үзэл хандлагатай оюутан суралцагчийг буй болгох нь нэн тэргүүний зорилт юм. Ийм үзэл хандлагатай оюутан суралцагчид бүгд бичих чадварыг сайн эзэмшиж чадна гэсэн санааг дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Унших чадвар, төлөвлөх, бичих үйл явц /process/, зохион бичлэг /product/, хянах, сэдэв сонгох, асуудлыг тодорхойлох, үг сонгох, асуудал дэвшүүлсэн эсээ, ойлгомжтой байх

Олон Улсын Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD)-аас 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдөр зарласан Сурагчийн Олон улсын Үнэлгээ /PISA/-ний “Унших чадвар” буюу ойлгож унших, уншсанаа эргэцүүлж бодох, эсээ бичих, өөрийгөө илэрхийлэх чадварыг тогтоох үзүүлэлтээр Монгол улс 81 орноос 65 дугаарт орсон билээ.

Мөн эх зохион бичих болон эсээ бичих чадварын талаарх судалгаанд хамрагдсан оюутнууд “Оюутан сургалтын явцад эсээ бичих шаардлага гардаг уу гэхэд нийт оюутны 23.8 % үргэлж, 42.1 % ихэвчлэн, 30,3 % заримдаа, 2.5 % бараг үгүй, 1.3 % огт үгүй гэж (Жавзанпагма, 2019, 40), оюутны эсээ бичих чадварыг асуулгаар тодруулахад судалгаанд оролцсон оюутны 2.5 % маш сайн, 17.5% сайн, 23.8 % дунд, 40% муу, 16.2 % маш муу гэж хариулсан байна. (Жавзанпагма, 2019, 39). Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан оюутны 95% эсээ бичих хэрэгцээ шаардлага гардаг боловч 80 % нь эсээг хангалттай бичиж чадахгүй, 60 % шахам хувь нь эсээ бичиж огт чадахгүй” гэсэн дүн гарчээ.

Хэдий сургууль, боловсролын байгууллага “Хүүхэд юмс үзэгдлийг танин мэдэж, ойлгож ухаарсны хэрээр сэтгэн бодох, түүнийгээ бусдад илэрхийлэх хамгийн бүтээлч чадвар нь бичгийн чадвар билээ. Эх хэлний хичээлээр хэлний зүйн мэдлэг олгох, үсгийн дүрмийн алдаагүй бичиж, түгдрэлгүй түргэн унших

зэргээс гадна зохион найруулж бичих чадвар сургах нь хамгийн чухал (Оюумаа, 2020)” хэмээн бага ангиас нь эхлэн хүүхдэд унших бичих мэдлэг чадварыг олгодог ч үр дүн ийнхүү хангалтгүй байгаагийн учрыг олоход бидний судалгаа тодорхой хариу өгөх болно.

Ингээд бид МУИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн намрын улиралд “Монгол хэл бичиг, найруулга” хичээлийг сонгон судалсан 100 оюутнаар 2 төрлийн “эсээ” нийт 200 орчим бичвэр бичүүлж, бичих явц, гүйцэтгэлд шинжилгээ хийхэд, оюутан суралцагч нарын бичих чадвар мөн л хангалтгүй байсан бөгөөд тэдний бичих чадвараа хөгжүүлэхэд нь дараах саад бэрхшээл тулгарч байна. Үүнд:

1. Бичих чадвар эзэмших талаарх онолын мэдлэг дулимаг байна.

Сэтгэц хэл шинжлэлд хүний хэлэхүйн үйл ажиллагааг ерөнхийд нь ойлгох ба бүтээх гэж хуваан үздэг бөгөөд хэлний дөрвөн үндсэн чадварын дундаас унших сонсох нь ойлгох үйл ажиллагаанд, ярих бичих нь бүтээх үйл ажиллагаанд хамаарна. Иймээс бичих чадвар нь хүний оюуны үйл ажиллагааны нэгэн дээд хэлбэр болохын хувьд хамгийн ярвигтай, үлэмж цаг зарцуулдаг үйл ажиллагаа юм.

Эрдэмтэд бичихүйг ерөнхийд нь бичихэд бэлтгэх /prewriting/, бичих /writing/, засаж бичих /rewriting/ гэсэн үндсэн гурван үе шаттай (D.G.Rowman.1965) гэж үздэг.

Энэ талын нарийвчилсан судалгаа буюу зохион бичих үйл явцыг сэтгэл зүйн загвараас Ж.Хайерс (J.R.Hayers)-Л.Флувер (L.S.Flower)-ын загвар, К.Берейтер (C.Bereiter)-М.Скардамалия (M.Scardamalia)-гийн загвар, А.Рэймс (A.Raimes)-ийн загвар зэрэг нь алдартай бөгөөд зохион бичих процессыг суралцагчийн танин мэдэх үйл ажиллагаа, сурах арга барилтай холбон оновчтой загварчилсан (Дэлгэрэхцэцэг, 2008, 40) хэмээн тооцдог байна.

Манайд бол бичвэр/product/-ийг голчлон судлаад бичих үйл явц /process/-ыг буюу хүн аливаа зүйлийг бичихэд сэтгэц танин мэдэхүйн ямар үйл ажиллагаа явагддаг талын судалгаа хомс байна. Энд Ц.Дэлгэрэхцэцэгийн “Япон хэлээр найруулан бичих чадварыг дээшлүүлэх онол аргазүйн асуудал” диссертацийн эхний бүлгийн судалгааг онцлон дурдах нь зүйтэй.

Ингээд бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын бичвэр, бичих үйл явцаас ажиглахад бичихэд бэлтгэх /prewriting/, бичих /writing/, засах /rewriting/ гэсэн үндсэн гурван ойлголтоос зөвхөн “бичих” үйлийг л гүйцэтгэх хандлагатай байна. Хамгийн чухал хэсэг нь нөгөө хоёр гэж үздэг ба нэн ялангуяа, бичихэд бэлтгэх /оюун ухаандаа “бичих”, мэдээлэл боловсруулах brainstorming/ гол үйлээ орхигдуулж, шууд үзэг цаас барьж суудаг нийтлэг дутагдал байна.

Хэдийгээр Ц.Өнөрбаян, Ж.Батбаатар нар “Эсээ бичихүйн үндэс” бүтээлийнхээ Эсээ бичихүйн үе шат алхмууд бүлэг сэдвийн хүрээнд “Бичихийн өмнөх буюу бэлтгэл шат” гэсэн хэсэгт бичихэд бэлтгэх /prewriting/ тухай нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг ч сургалтын үйл ажиллагаанд төдийлөн бууж харагдахгүй байна.

Энгийн үгээр хэлбэл, “бичих үйл явц” гэдэг бол хүний оюун тархины үйл ажиллагаа гэдгийг оюутан суралцагчдад ойлгуулахад багш гол анхаарлаа хандуулах ёстой бөгөөд нэгэнт хүн тархиндаа төсөөлж, төлөвлөсөн зүйлийг цаасанд буулгах нь дараагийн алхам юм.

Энэ талаар П.Батхуяг “ Ихэнх нь эсээг гарчиг тавиад л шууд бичээд эхлэх мэтээр боддог. Харамсалтай нь тийм биш. Бичиж эхлэхээс өмнө хүмүүсийн наргиан болгон ярьдгаар “наян юм” бий. Түүнийг онолын хүрээнд дараах байдлаар систем болгожээ.

- Ажиглалт ба санаа олох
- Төсөөлөл ба ургуулан бодох
- Судлах ба баримтжуулах

-Эхлэх ба бичих (Батхуяг, 2018, 11) хэмээн оновчтой хэлсэн байдаг. Ташрамд дурдахад, бид бичих чадварын тухай бичиж байгаа атлаа яагаад зөвхөн эсээний тухай жишээлж бичээд байна гэвэл, нэгдүгээрт, эсээ бичлэг бол оюутан суралцагчдын мэдлэг оюуныг тэлдэг хамгийн чухал бичвэрийн төрөл болсон, хоёрдугаарт, бид судалгаанд хамрагдсан оюутнуудаар эсээ бичүүлж, түүн дээр ажиглалт судалгаа хийж байгаатай холбоотой юм.


Хоёрт, бичвэрийн төрлүүд, тэдгээрийн ялгааны талын онолын мэдлэг хомс байна. ЕБС-ийн сургалтын төлөвлөгөө ёсоор эсээний тухай тодорхой хэмжээний мэдлэг эзэмшдэг ч “эсээ” болоод аливаа зүйлийн талаарх “бодол сэтгэгдэл”-ээ ялгаж салгаж чадахгүй байна. Дэлхийн утга зохиолын нэр томьёоны цахим ([https:// literarydevices.net](https://literarydevices.net)) тайлбар толь бичигт эсээний 19 төрөл бий гэж тэмдэглэсэн байна. Тиймээс оюутан суралцагчдын хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бичих ур чадвар, эсээ бичих талаар мэдлэгийг тогтолцоотойгоор олгох шаардлага тулгарч байна. Бид эдгээрээс дөрвөн төрлийн эсээг Ерөнхий Боловсролын болоод их дээд сургуулийн сургалтын агуулгад багтаан судлах ёстой гэж үзсэн бөгөөд энэ талаар тусгайлан өгүүлсэн болно.

Гуравт, Оюутнуудын бичиж буй эсээ бичвэрүүд ямар бүтэцтэй нь тодорхойгүй байна. Бидний сонгож ажиглалт хийсэн эсээнүүдийг бүтцийг авч үзвэл, догол мөргүй, хэдэн цогцолбороос тогтсон нь харагдахгүй, үргэлжилсэн бичвэр бичсэн нь нийт эсээний 50-60 хувийг эзэлж байна.

Өнөөдөр эсээ хэрхэн бичих, эсээний бүтэц, загварын талаар харьцангуй олон ном сурах бичиг гарсан, мөн интернэтээр хангалттай мэдээлэл авах боломжтой болсон байна. Мөн ЕБ-ын болоод их дээд сургуульд тодорхой агуулгыг заадаг болсон юм. Тухайлбал:

Асуудал дэвшүүлсэн эсээ бичье гэвэл эсээний доорх бэлэн загварыг ашиглаж бичих төлөвлөгөөгөө зохиож болно.





Оюутан сурагчдын бичсэн зүйлээс бичвэрийн эхлэл, гол, төгсгөл хэсэг тодорхой цогцолборуудтай байвал зохистой. Бид ЕБ-ын сургуульд эх задлал, цогцолбор, өгүүлбэрийн тухай олонтоо ярьдгийн хэрээр эх зохиохдоо ядаж эхээ догол мөрөөр ялгах хэмжээний мэдлэг чадварыг эзэмшүүлбэл зохино.

2. Сэдэв сонгох

Бичигч дараах дөрвөн чухал асуултад хариулах ёстой.

1. Яагаад (яахын тулд) бичих гэж байна вэ?
2. Хэнд зориулж бичиж байна вэ?
3. Юуны тухай бичиж байна вэ?

Чухам юу хэлэх гэж бичиж байна вэ? (Өнөрбаян, 2007)

Бичих чадвараа сайжруулахыг хүсэж буй оюутан суралцагчдад тохиолддог нэг асуудал бол юуны тухай бичих вэ буюу сэдэв сонгох юм.

Энэ талаар, ер нь бичих чадвар хэрхэн эзэмших тухай профессор Ц.Сүхбаатар “Найруулан бичиж чадвар:

1. Хөдөлмөрч эрмэлзэл
2. Байнга ажиглах
3. Уйгагүй унших
4. Бүтээлч дуурайл
5. Бичих сэдвээ гүн ойлгох
6. Зөв төлөвлөх
7. Амттай байх (Хүнд хүрэхээр сонирхол татах)

8. Үгийг оновчтой сонгох

9. Хэлний дүрслэх болон яруу хэрэглүүрийг зохистой ашиглах

Бичсэн зүйлээ ахин дахин засах (Ц.Сүхбаатар, 1993, хууд. 35) гэсэн байдаг ба үүний тавдугаарт **Бичих сэдвээ гүн ойлгох** чухал болохыг дурджээ.

Ташрамд дурдахад, Ц.Сүхбаатар энэхүү 10-н зүйлийн зөвлөмж нь дэлхийн томоохон мэдээллийн www.wordstream.com сайтад 2023 оны 11 дүгээр сард нийтлэгдсэн Английн зохиолч, сэтгүүлч Дан Шеваны бичсэн “Бичих чадвараа сайжруулах 16 арга зам” нийтлэлийн агуулгатай үндсэндээ тохирч байгаагаас үзвэл өнөө хэр үнэ цэнээ алдаагүй байна.

Дан Шеван бичих чадвараа хөгжүүлэхийн тулд

1. Зөв бичгийн болоод хэлзүйн дүрэм, бичлэгийн ерөнхий зарчмуудыг эзэмш
2. Уйгагүй бич (Хөдөлмөрч эрмэлзэлтэй байх Ц.С)
3. Байнга унш
4. Бичсэн зүйлээ уншуулж, зөвлөлдөх хамтрагчтай бол
5. Уулзалт, семинар, сургалт дамжаанд хамрагд
6. Унших дуртай эх, зохиолоо задлан шинжил
7. Унших дуртай зохиолчийнхоо хэрхэн бичиж байгааг дууриа
8. Бичих зүйлээ төлөвлө
9. Бичсэн зүйлээ ахин дахин зас /Edit your work ruthlessly/
10. Анхны ноорог ямагт засагддагийг сана
11. Найдвартай редактортай бол
12. Шаардлагагүй үг хэллэгийг бүү хэрэглэ(Үг сонголтод анхаар Ц.С)
13. Бичих чадвар өмнөхөөсөө хэрхэн өсөж сайжирч байгааг мэдэр
14. Хэлье гэснээ зоригтой хэл, бичье гэснээ л бич. Бүү ай
15. Бичих зүйлийнхээ талаар сайн судал

Яг одоо бичиж эхэл, бүү хойшлуул (Shewan, 2023) зэргийг анхаарах ёстой гэж үзжээ.

Энд мөн бичих зүйлийнхээ талаар сайтар судлах /Make sure you do adequate research on your topic/-ыг чухалчилж байна.

Бичих зүйлийнхээ талаар сайтар судалж, бичих сэдвээ гүн ойлгоно гэдэг бол нийт ажлынхаа тал хувийг гүйцэтгэчихлээ гэж үздэг.

Бидний судалгаанаас үзэхэд, Нэгдүгээрт, оюутнууд сэдэв сонгохдоо би уг хичээлээр бичих чадвар эзэмших ёстой, тийм учраас сэдвээ зөв сонгох нь чухал хэмээн ухамсарлахгүй, “нэг юм” бичиж дүн оноо авах гэсэн ерөнхий хандлагаасаа салж чадахгүй байна. Хоёрдугаарт, нийт оюутны 80 орчим хувь нь утаа, түгжрэл, ажилгүйдэл, архидалт гэх мэт улиг болсон, хэт ерөнхий сэдэв сонгож байна. Энэ нь тэдний бичихүйд хэрхэн хандаж байгаа, бичих сэдвээ хэрхэн ойлгож байгааг харах гол үзүүлэлт юм.

Ийм хандлагатай, бичих зүйлээ судлахгүй, ойлгохгүй байгаа нөхцөлд бид бичих чадварын тухай ярих нэн хүнд юм. Яагаад ийм идэвхгүй байдалд хүрэв, судалгаанаас үзэхэд ЕБС-ийн эх хэлний сургалтад хүүхдээр эх зохион

бичүүлэхдээ одоо хүртэл “Хавар” , “Намар”, “Мөрөөдөл”, “Би”, “Эх орон”, “Миний мэргэжил”, “Миний гэр бүл”, “Хамгийн сайхан дурсамж”, “Тэвчээр”, “Хайр” гэх сэдвийг мэт өгсөөр байгаа, хэтэрхий бүтээлч бус байдагтай холбоотой байна.

ЭЕШ-ын Монгол хэл, бичгийн шалгалтын 2015 онд *Надад тохиолдсон нэгэн явдал* Үгийн тоо 200-250 (Бичихдээ бүтэц, өнгө аяс, сэдэв, агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан зөв найруулгатай бичээрэй)

2016 онд *Миний хамгийн дуртай нэвтрүүлэг* Үгийн тоо 200-250 (Энэхүү нэвтрүүлэг танд ямар ухаарал, баяр баясал төрүүлсэн хийгээд яагаад “хамгийн дуртай нэвтрүүлэг”-ээр онцолж байгаагаа баталж нотолж бичнэ үү)

2017 онд *Өөрийгөө хөгжүүлээрэй* Үгийн тоо 200-250 (Ятгасан эх нь бичигчийн байр суурь, түүний шалтгаан үндэслэл, энэхүү шалтгааны нотолгоо гэсэн гурван хэсгээс бүтнэ)

2018 онд *Миний хамгийн нандин дурсамж* Үгийн тоо 200-250

(Юуны учир дурсамж таны сэтгэлд хоногшсоныг онцолж баталж, нотлох)

2019 онд *Би ээжийнхээ нүүрэнд үрчлээ нэмж, гарыг нь мойног болгосон* Үгийн тоо 180-200 (Найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл, уран дүрслэлээр баяжуулахыг зөвлөж байна) гэх зэрэг эх зохиох ажлын сэдвүүдээс харахад ч цөм “би”, “миний”, “надад”, “өөрөө” гэсэн байгаа нь нөгөө би би гэсэн бүтээлч бус бичлэгийн хэв маяг, үзэл хандлага, уншигч харилцагчаа тооцоолдоггүй байдлыг өөгшүүлсэн янзтай байна.

Иймд юуны түрүүнд /**нэгд**/ багш сурагч оюутнаар эх зохиолгохдоо бүтээлч сэдэв сонгох хэрэгтэй байна. Энд www.journalbuddies.com сайт дахь Бүтээлч бичвэрийн сэдвийн жагсаалтаас жишээ болгон үзүүлье.

...Хэрэв чи амьтан байсан бол ямар амьтан байх байсан бэ?

Өөрийн дуртай спортын багийн тухай бичнэ үү

Хэрэв чи хүний бодол уншиж чаддаг байсан бол хэний бодлыг унших байсан бэ? Яагаад?

Чи зурхайд итгэдэг үү? Худлаа гэж боддог уу? эсвэл үнэний ортой гэж боддог уу?

Хэрэв чи харь гаргийн хүнтэй таарвал юу асуух вэ?

Чиний дуртай видео тоглоом юу вэ?

Чи хэзээ нэгэн өдөр цаг хугацаагаар аялбал аль үе рүү явах вэ?

Чи өөрийнхөө нэрэнд дуртай юу?

Эцэг эхчүүд яагаад бяцхан охидыг ягаанаар, хөвгүүдийг хөх өнгөөр хувцасладаг вэ?

Зайрмагаар бүтээсэн ертөнцөд амьдардаг хүүхдүүдийн тухай бичнэ үү?

50 жилийн дараа дэлхий ямар байх вэ?...(Journal, 2022) гэх мэт.

Хүүхэд багаасаа ийм бүтээлч сэдвээр эх бичсэнээр бүтээлч сэтгэхүй (creative thinking)-тэй, бүтээлч чанартай хүн болдог. Энэ нь өнөөдөр манай залууст их дутагдаж байгаа ур чадвар юм.

Хоёрт, Дэлхийн эрдэмтэн судлаачдын сэдэв хэрхэн сонгох талаарх заавар зөвлөмжтэй танилцах хэрэгтэй байна. Тухайлбал:

Канадын Торонтогийн их сургуулийн доктор, Essayjack-ийг үндэслэгч, судлаач Линди Ледоховски Асуудал дэвшүүлсэн эсээ бичихэд сэдвээ хэрхэн сонгох талаар

1. Өөрийнхөө хамгийн сайн мэддэг, дур сонирхолтой зүйлээ бич
2. Сонгосон сэдвээ өөрөө судал. Нийгмийн сүлжээний энэ их мэдээлэлд итгэх хэрэггүй.

3. Хэнд зориулж бичиж буйгаа тодорхойл

4. Аль болох улиг болоогүй, тэр бүр хүн хөндөөгүй, эмзэг содон сэдвийг ол
- Амьдралаас урган гарсан сэдвийг сонго (Бид аюулгүй орчинд амьдарч байна уу?, Нийтийн тээврийн хүрэлцээ ямар байна гэх мэт) (Ledohowski, 2023) гэжээ.

Үнэн хэрэгтээ бид найруулан бичих чадварт сургах гэхлээр нэг л номоо хуулаадл “ноолоод” л ирсэн нь нууц биш бөгөөд дээрх мэт заавар зөвлөгөөнүүдээс олон зүйл санаа авах, хэрэгжүүлэх нь чухал юм.

3. Асуудлаа ончтой тодорхойлох

АНУ-ын боловсролын философич Жон Дью “Бүтээлч сэтгэлгээ нь сурагчид асуудлыг хэрхэн дэвшүүлж тавихаас эхэлдэг” хэмээсэн байдаг.

Сэдвээ сонгосны дараагийн чухал асуудал бол сэдвээ нарийвчлах буюу асуудлаа ончтой тодорхойлох болно.

Судалгаанд хамрагдсан оюутны 80% нь сэдвээ сонгосны дараа би энэ сэдвийн хүрээнд ямар асуудлыг дэвшүүлэх гэдгээ тодорхойлж чадахгүй байна. Улмаар ямар баримт нотолгоогоор яаж шийдвэрлэх вэ гэдэг бичих төлөвлөгөөгөө гаргах учиртай.

Өөрөөр хэлбэл, дэвшүүлж буй асуудал маш тодорхой байх ёстой.

Боловсролын салбар өндөр хөгжсөн орнуудын оюутнуудын бичдэг Асуудал дэвшүүлсэн эсээ ¹(Argumentative essay)-ний сэдвээс энэ маш тодорхой харагддаг ба энд жишээ болгон АНУ-ын “Indeed” карьер хөгжлийн төвөөс 2023 оны хамгийн их асуудал болсон 125 сэдвийн Боловсролын салбарын сэдвүүдийг сонирхуулъя,

Коллеж, их дээд сургуулиуд оюутан тамирчдаа цалинжуулах ёстой юу?

Улсын сургуулиудад шашины чиглэлийн оюутны клуб, байгууллагуудыг зөвшөөрөх ёстой юу?

Оюутнууд заавал тангараг хэлэх /униих/ ёстой юу?

Сурагчдад дүрэмт хувцас өмсөх албатай юу?

Биеийн тамирын хичээлийг дүгнэх ёстой юу?

Коллеж, их сургууль төлбөргүй байх уу?

Коллежийн оюутнуудыг Оюутны клуб (Greek life) оролцохыг хориглох нь зөв үү?

Сургуульд урлагийн хичээл заавал байх нь зөв үү?

¹ З.Айжан Л.Түдэв, О.Дашбалбар нарын энэ төрлийн эсээг Асуудал дэвшүүлсэн эсээ гэж ангилжээ. З.Айжан. (1997). Л.Түдэвийн эссе, түүний онцлог, ур чадвар. Улаанбаатар Магистрын дипломын ажил

Хөгжим болон бусад урлагийн төрлүүд онлайнаар үнэ төлбөргүй байх ёстой юу?
 Шалгалтан дээр хуулсан (хууран мэхэлсэн) оюутныг шийтгэх ёстой юу?
 Сургуулиуд оюутнуудын компьютер болон бусад технологийн хэрэглээг хязгаарлах ёстой юу?
 Охидын болон хөвгүүдийн сургууль (Single-sex education) гэж ялгаж боловсрол олгох нь энгийн боловсрол (Co-education) олгохоос дээр үү?
 Сургууль жилийн турш хичээллэх нь зөв үү?
 Гэрийн даалгавар өгөхгүй байсан дээр үү?
 Бүх сурагчид сургууль дээрээ өглөөний цай, өдрийн хоолыг үнэ төлбөргүй авах ёстой юу?
 Хувийн сургууль хэтэрхий өрсөлдөөнтэй байна уу?
 Сурагчид хангалтгүй дүн авсны төлөө багш нарт нь хариуцлага тооцох ёстой юу?
 Ахлах сургуулийн сурагчид хичээлээ сонгох нь зөв үү?
 Оюутнууд гадаад хэл сурах ёстой юу?
 Багш нар сурагчдад дүн тавих ёстой юу?
 Стандарт тестүүд үр дүнтэй юу?
 Спорт, өсвөр насныхны сурлагын амжилтад сөргөөр нөлөөлдөг үү?
 Оюутнууд шалгалт өгөхдөө компьютер ашиглахыг зөвшөөрөх үү?
 Ахлах сургууль төгсөгчид карьераа эхлүүлэх эсвэл коллежид орохоосоо өмнө нэг жил завсарлах ёстой юу?
 Хичээл 9 цагаас хойш эхлэх нь зөв үү?
 Онлайн сургалт үр дүнтэй юу?
 Дунд, ахлах ангийн сурагчид цагийн ажил хийж болох уу?
 Багш нар цалингаасаа илүү орлого олж болох уу?
 Хүүхдүүд хичээлээ таслах тохиолдолд эцэг эхчүүдийг шийтгэх нь зөв үү?
 Бүх хүүхэд коллежид заавал орох ёстой юу?
 Оюутнууд багш нараа дүгнэх сонголт байх уу?
 Багш нар хүүхдэд гар хүрэн шийтгэж болох уу?
 Сургуулиуд зэвсэглэсэн харуул хамгаалалттай байх нь зөв үү? гэх мэт.
 Сургуулийн номын сангууд сурагчдад зарим номыг хориглох ёстой юу?

Цаашид бид энэ төрлийн эсээний сэдэв, агуулгыг ингэж бичиж тогтох ёстой. Тухайлбал: Түгжрэлийг хэрхэн шийдэх сэдвийн хүрээнд “Машиныг тэгш сондгойгоор явуулах шийдвэр гарчээ. Та үүнийг дэмжих үү? үгүй юу? Дэмжиж байвал дэмжиж байна гэдэг талаас үндэслэл, баримт нотолгоогоо гаргаж бичнэ. Дэмжихгүй бол дэмжихгүй гэдэг талаас үндэслэл, баримт нотолгоо гаргаж нотлон дүгнэж бичнэ. Цаашилбал:

- 11 сарын 26-ны өдөр нийтээр тэмдэглэх баярын өдөр үү?
 - Үнэн гэж бий юу? Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцэх үү?
 - Ардчилал гэж юу вэ? Монгол ардчилсан улс уу?
 - Гадаадын Хөрөнгө Оруулалтын хуулийг дэмжих үү?
 - Орос Украины асуудал дээр таны байр суурь...
- гэх мэт

Ийнхүү ямар асуудлыг хөндөх вэ гэдгээ тодорхойлж сурах нь чухал юм.

Мөн “МУИС Пресс” хэвлэлийн газраас 2015 хэвлүүлсэн “Илтгэх урлагийн онол, арга зүй” номын хавсралт 2-д Монголын илтгэх клубүүдийн мэтгэлцээний гол 124 сэдвийн жагсаалтыг нийтэлсэн нь оюутнуудад сэдвээ сонгох, асуудлаа тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Тухайлбал:

-Цаазаар авах ялыг хуулиар хориглох нь зөв үү?

-Монгол улс Ерөнхийлөгчийн засаглалд шилжих нь зөв үү?

-Иргэд хотын даргаа сонгох уу?

-Малчдад төрөөс дэмжлэг олгодог буруу юу?

-Архины үнийг нэмэх нь зөв үү? (Д.Батжаргал, 2015, хууд. 139) гэх мэт.

Энэ талаар Д.Эрдэнэсан “Эргэн тойрны олон янзын асуудалд хүмүүс өөр өөрийн байр сууриас ханддаг нь хэвийн зүйл гэдгийг багш сурагчдад ойлгуулах ёстой бөгөөд үзэл бодлоо илэрхийлж, хамгаалах боломжийг хүүхдэд олгож байх шаардлагатай. Сурагчид аливаа асуудлыг эргэцүүлэн тунгаан бодсоны үндсэнд байр сууриа тогтоож, үзэл бодлоо тайлбарлах, бусдын үзэл бодлыг сонсож сурахад чиглэнэ. Хичээлийн 15 минутаас хэтрэхгүй хугацаанд багш асуудал дэвшүүлж хэлэлцүүлэг хийж болно. Асуудал нь сурагчид “Тийм, үгүй” гэсэн хоёр хариултын аль нэгийг сонгох боломжтой байвал оновчтой (Эрдэнэсан, 2021, 162)” хэмээн бичсэн нь олзуурхууштай бөгөөд одоо манай багш нар үүнээс үлгэр аван, энэ асуудалд онцгой анхаармаар байна.

Тэрээр “Эсээ зохион найруулж бичих явцад аливаа асуудлыг олон өнцгөөс харж, тунгаан бодох, асуудалд ул суурьтай хандах, үнэлж дүгнэх, бусдаас өөрөөр бүтээлчээр сэтгэх, бусад зүйлтэй харьцуулан ажиглаж судлах, мөн чанарыг нь тодорхойлох, үндэслэл нотолгоо гаргах, ажиглалт судалгаа хийх гэх мэт хувь хүнээс ихээхэн чадвар шаарддаг (Эрдэнэсан, 2021, 162) гэсэн нь үнэхээр чухал юм.

Ийнхүү асуудал дэвшүүлэн дэмжих (тийм) эсвэл үгүйсгэн (үгүй) бичих нь угаас асуудал дэвшүүлсэн эсээний амин сүнс бөгөөд нэн ялангуяа оюутан суралцагчийн аливаа асуудлыг тунгаан бодох чадвартай болгоход онцгой үүрэгтэй юм. Бид энэ талаар тусгайлан өгүүлсэн болно.

Манай өмнө үеийн боловсролын тогтолцоонд энэ аргыг хэрэглэдэг байсан төдийгүй тухайн үеийн боловсролын “бүтээгдэхүүн”-үүд харьцангуй юмыг бодож тунгааж шийддэг байсан билээ. Матери анхдагч уу, ухамсар анхдагч уу хэмээн маргаж мэтгэлцэж байсан хүн бүр үүнийг мэднэ.

Хэдийгээр “Асуудал шийдвэрлэх сургалтын арга” хэмээн ярьдаг ч амьдралд хэрэгжүүлэхгүй байна. Уг сургалтын аргыг ер нь ашигладаггүй, эсээг тэр бүр бичүүлдэггүй нь унших чадварын шалгалтад хангалтгүй үнэлгээ авсны нэг шалтгаан юм. Уг шалгалтын ажлаас ажиглахад монгол хүүхдүүдийн дийлэнх асуултад хариулж буй боловч Яагаад? гэдэгт ихэнх нь хариулаагүй байгаад гол учир байна.

4. Ойлгомжтой байх

Яагаад? гэдэгт хариулахгүйн гол шалтгаан ойлгохгүй байгаад оршино. Хамгийн гол нь таны бичсэн зүйлээс яагаад (яахын тулд) үүнийг бичсэн бэ? чухам юу хэлэх гэж үүнийг бичсэн бэ? гэдэг таны санаа тов тодорхой харагдаж, ойлгогдох ёстой.

Хэл бол хүмүүсийн хоорондын харилцааны хэрэглүүр, нөгөө талаар хүн хоорондын харилцан ойлголцох хэрэглүүр. Харамсалтай өнөөдөр бид эх хэлээрээ харилцан ойлголцоход хүндрэл учраад байгаа нь нууц биш. Монгол хүний ярьж байгаа зүйл, монгол хүний бичсэн номыг монгол хүн ойлгохгүй тохиолдол цөөнгүй байна. Зөвхөн би л ойлгохгүй байгаа байх хэмээн дор дороо сэтгэж “Ойлгохгүй байна” гэж хэлэхээс эмээн явсаар улам хүнд байдалд орж байна. Аливаа шинжлэх ухааны хэл нийт хүнд ойлгомжгүй байдаг ч түүнийг хялбаршуулсан зарим сурах бичиг, сургалтын материалыг сурагч нь битгий хэл багш нь ойлгохгүй боллоо.

Энэ тухай “Голомт” банкны захирал асан, судлаач Ө.Ганзориг Youtube сувагт өгсөн “Бичих чадавх нь оюуны хамгийн дээд илрэл” гэсэн ярилцлагадаа: *Анх оюутан байхад надад санхүүгийн менежментийн ном байсан. Би нэг өгүүлбэрийг уншаад ерөөсөө ойлгоогүй, 10-н удаа уншаад ч ойлгоогүй. Тэр өгүүлбэр нь 120 үгтэй өгүүлбэр байсан. Тэгээд би дараа нь Худалдаа Хөгжлийн Банканд дилер болчихоод нөгөө их сургуульд сураагүй юмнуудаа нөхөж сурч байна шүү дээ... Тэгээд би англи ном аваад нөгөө ойлгож чадахгүй, нөгөө хэцүү байсан юмнуудаа уншсан чинь “хүүхдийн тоглоом”. Тэгээд би анх удаа би чинь тэнэг хүн биш юм байна гэж, одоо 21-тэй дээ ойлголоо шүү дээ би чинь. Дунд сургуульдаа тийм тааруухан сурагч юм чинь за би бол ер нь мангар л гэж бодож байсан. Тэгээд анх удаа би тэнэг биш энэ бичсэн өгүүлбэр чинь тэнэг байсан юм байна шүү дээ гэдгийг ойлгосон (Ө.Ганзориг, 2022)* гэсэн байдаг. Энэ хүний ярьсныг тэр чигээр нь буулгалаа, зөв буруу гэж шүүх гэсэнгүй.

Гэтэл техник технологи хөгжсөн өнөө үед дэлхий нийтээр та 6-10 насны хүүхэд уншаад ойлгохуйцаар бичих ёстой гэж үзэж байна. Нэг талаар энэ нь хэлний хэрэглээг явцууруулж буй мэт боловч ойлгомжгүй, хүнд хэв маягаар бичиж ирсэн уламжлалаас дэвшилттэй бөгөөд хэмжээ тунг тааруулах нь чухал юм.

Манай судалгаанд хамрагдсан оюутнуудын чөлөөт эсээний сэдвүүд (өөрсдөө сонгосон) Амьдрал гэж юу? Үхэл...гэх мэт нэлэнхийдээ хүнд байна.

Францын байгаль судлаач, эрдэмтэн Жорж-Луи Леклерк, гүн де Буффон (1707 -1788)

1753 онд “Discours sur le style” бүтээлээ хэвлүүлж, үүндээ “Найруулга бол хүн өөрөө юм” “Le style c’est l’homme même” (“The style is the man himself”) (Buffon, 1999) хэмээх алдарт үгээ хэлж үлдээжээ.

“Хэл яриа бол хүн өөрөө юм” гэж Ц.Сүхбаатар багшийн орчуулсан энэ үгийн утга бол таны бичсэн зүйлээс таны хэн бэ? хэдэн настай вэ? юу хүсэж мөрөөддөг, юманд хэрхэн яаж ханддаг зэрэг харагдах ёстой гэсэн үг. Гэтэл манай оюутан залуусын бичвэрээс хижээл насны, нэлээд юм үзсэн шал өөр хүн харагдсан, маш “хүнд” бичвэрүүд байна. Энэ бичвэрүүдийг унших багш хүнд ч маш хүнд байдаг. Энэ нь мэдээж дан ганц оюутан суралцагчдын алдаа дутагдал бус, Багш суралцагчийг за энэ сэдвээр бич гэнгүүт суралцагч шууд “өөр хүний дүрд орж” бичдэг нь манай боловсролын тогтолцооны гажиг юм. Учир нь, хүүхэд би буруу бичих болов уу, багш юу гэх бол, би ямар дүн авах бол гэдэг асуудлууд бичихээс илүү хүүхдэд дарамт болдог ба бид бичих чадварын шалгуур, шалгах үзүүлэлтээ эргэн харах хэрэгтэй.

Цаашид оюутан суралцагчийг өөрийгөө шууд илэрхийлдэг, хөнгөн маягаар бичих арга дадалд сургахгүй бол бичих чадвараа амьдрал ахуйдаа ашигладаг мэргэжилтэн бэлтгэж чадахгүйд хүрлээ. Адгийн наад зах нь хүүхэд ЕБС-аа төгсөөд гадаадад суралцахын тулд Өөрийгөө илэрхийлэх эсээ (Personal statement) бичихэд бүтэн жил зарцуулж байгаа жишээ олон байна. Үүнийг бид сургуулиар олгох ёстой. Энд нэгэн жишээ дурдъя.

Нийслэлийн 24 дүгээр сургуулийг төгсөгч, одоо АНУ-ын Виржиниа мужийн Арлингтон хотод амьдардаг, Миамагийн их сургуулийн оюутан Номинзул (Youtube суваг Nomikuu) Өөрийгөө илэрхийлэх эсээ бичсэн талаараа ... *Personal statement гэж байгаа энэ бол монголоор Хувь хүний эсээ гэдэг билүү яг өөрийг чинь илэрхийлж байгаа эсээ, 600 үгтэй байдаг билүү...Энэ бидэнд хамгийн их тулгамдаж байсан, хамгийн их цагаа зарцуулж байсан, хамгийн чухал нь, оноонууд чинь өндөр байлаа гэхэд адилхан өндөр оноотой хүүхдүүд байгаа, тэд нараас чи юугаараа ялгарах вэ гэвэл бичсэн эсээгээрээ л ялгарч чадна. Эсээн дээрээ төвлөрөх хэрэгтэй. Би болохоор эхний жилдээ dark эсээ бичиж байсан, Аймаар тийм зовлонтой эсээ, уншиж байгаа хүн стресстэхээр, Тийм болохоор би сургуулиуддаа тэнцээгүй байх гэж бодсон. Тэр чинь миний амьдралыг харах өнцгийг харуулж байгаа болохоор...* (Номинзул, 2021) гэж бичсэнээс тодорхой харж болно.

Энэ хүүхэд эхний жил эсээгээ бичиж 10 гаруй сургуульд явуулаад тэнцээгүй боловч дараа жил нь хэд хэдэн сургуульд тэнцжээ.

Мөн сүүлийн үед бичвэрийн ойлгогдох байдал нь өгүүлбэр дэх үгийн тоотой холбоотой гэсэн судалгаанууд гарсан байна. Сэтгэл судлаачид 25-аас илүү үгтэй нийлмэл өгүүлбэр хүний шуурхай санах ойд ачаалал өгч мартагдах магадлал хоёр гурав дахин өсдөг гэж үздэг.

5. Товч байх

“Найруулж сурахад эзэмшвэл зохих хамгийн чухал чанарууд бол:

- Өгүүлж байгаа зүйл тодорхой
- Үг хэллэг оновчтой
- Үгийн баялаг арвин
- Нуршсан зүйлгүй товч
- Өөрийн гэсэн арга барилтай байх
- Уншигчдад нэгэн цэгц ойлголт өгөх
- Гоёж гангалан чамирхсан зүйлгүй энгийн байх (R.Georgin.Les secrets du style.Paris. 1961)
- Ойлгомжтой
- Сонирхолтой
- Яруу сонсголонтой

Гоо зүйн хэм хэмжээг харгалзсан байх (Ц.Сүхбаатар, Монгол хэлний найруулга зүй, 2007) гэжээ. Үүний нэг гол шаардлага бол нуршсан зүйлгүй товч байх юм.

Товч хураангуй ярьж бичих тухай сургасан үг сургаал цөөнгүй. Ардын үгэнд:

Олон үгэнд олзгүй

Цөөн үгэнд гарзгүй

*Олон хэлбэл улиг
Цөөн хэлбэл билиг
Үг дагвал улиг
Ном дагвал билиг...*

хэмээн үг ярианы илэрхийлэгдэх байдал нь үгийн олон цөөнөөс хамаарах төдийгүй оновчтой, ойлгомжтой, сургаалтай цөөн үг бол ухаан билигтний оюун ухааны чадвар гэдгийг тод томруунаар дүрслэн илэрхийлсэн байна. Ерөөс бид товч бөгөөд тодорхой найруулахын эрдмийг ардынхаа аман зохиолоос мэдэх нь чухал байна. Ардын аман зохиолын жижиг хэмжээний төрөл зүйлүүд, тухайлбал оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, үлгэр зэргээс хэрхэн товч хураангуй хэлбэрээр өргөн дэлгэр агуулга гаргахын үлгэр жишээг олж үзэж болох юм. (Б.Бямбадорж, 2014, хууд. 36)

Мөн сүүлийн үеийн бичвэрт өгүүлбэр дэх үг, цогцолбор дахь өгүүлбэрийн тоо аль болох цөөн, эхийн хэмжээ богино байх нь чухал гэж үзэж байна. Энэ нь мэдээллийн эрин үед, хүн үнэн худал мэдэгдэхгүй мэдээлэлд алхам тутам дарагдаж, улмаар мэдээллийг аль болох хурдан шуурхай авахыг чухалчилдаг болсонтой холбоотой юм. Ялангуяа, цахим орчинд хүмүүс 2-3 хуудас үргэлжилсэн урт зүйлийг нэг бүрчлэн уншихгүй, харин ч 2-3 өгүүлбэрт багтаасан мэдээ мэдээллийг унших болжээ.

АНУ-ын Хэвлэлийн Хүрээлэнгийн явуулсан судалгаагаар “Нэг өгүүлбэрийн дундаж урт 14 үгтэй байх хамгийн зохимжтой бөгөөд ийм эхийг уншигч уншсан зүйлийнхээ 90 гаруй хувийг ойлгодог бол урт өгүүлбэртэй эх буюу 43 үгтэй өгүүлбэрийг ойлгох чадвар 10 гаруй хувиар буурдаг Sources: “Readers’ Degree of Understanding,” American Press Institute. (AmericanPressInstitute, 2010) Мөн цаашилбал “Нэг цогцолбор дахь зохист өгүүлбэрийн тоо 3, Дээд хязгаар нь нэг өгүүлбэрийн үгийн тоо 25, цогцолбор дахь өгүүлбэрийн тоо 5-аас илүүгүй байвал бусдад уншигдах ойлгогдох магадлал нэмэгдэнэ” гэжээ.

Аливаа бичвэрийн ойлгогдох зэрэг нь дан ганц өгүүлбэрийн урт богиноос хамаарахгүй нь мэдээжийн хэрэг ч гэсэн бид үүнийг цаашид анхаарч судлах ёстой.

Энэхүү судалгаа нь сурагчдын унших, ойлгох чадвар эд яригдаж буй үед практик ач холбогдолтой юм. Манай хүүхдүүдийн унших ойлгох чадварын үзүүлэлт муу байгаагийн нэг шалтгаан энэ байхыг үгүйсгэхгүй.

Нөгөөтээгүүр, монгол албан бичгийн уламжлал, алдартай зохиолчдын ном бүтээлд нэг нийлмэл өгүүлбэрт орох үгийн тоо 200-300 хүрэх нь түгээмэл, тэр ч байтугай Д.Урианхайн 1989 онд бичсэн “Учрахуй хагацахуй” романы дэд боть “Анирт талын татах хүч” романы төгсгөлийн үг 1327, эрдэмтэн Д.Баттогтохын бичсэн “Богд Очирваань хайрхан” эсээ 1565 үгтэй нэг нийлмэл өгүүлбэрээс бүтсэн, урт байдаг онцлогтой.

Энэ нь дээр өгүүлсэнчлэн, бичгийн мэргэд, мэргэжлийн зохиолчдын нэг гол шалгуур. Эх хэлнийхээ баялаг үгийн сан, дүрслэх болон яруу хэрэглүүр, өгүүлбэрийн холбоосыг яаж ашиглаж болох гайхалтай боломжуудыг харуулсан сонгодог жишээ юм.

Харин зохиолч, яруу найрагч болох гээгүй, бичих ур чадвараа дээшлүүлэхээр суралцаж байгаа хүмүүс заавал урт өгүүлбэр бичих шаардлагагүй, мөн энэ нь хүний авьяас чадвартай холбоотой тул хүн бүр чадахгүй юм.

Бидний судалгаанаас үзэхэд, оюутан суралцагчид энэ талын мэдээлэл багатай, нэг өгүүлбэр дэх үгийн тоонд төдийлөн ач холбогдол өгдөггүй нь харагдаж байна.

6. Баримт мэдээлэл цуглуулах

Манайд эсээний тухай олон тодорхойлолт бий. Арга ч үгүй юм. Эсээ нь нэгэнт олон төрөл зүйл болон хөгжсөн тул өнцөг булан бүрээс харж тодорхойлох нь зүйн хэрэг. Гэхдээ бүх эсээнд байдаг нэг нийтлэг зүйл бол баримт. Тухайлбал:

Мишель дө Монтенийн “Нэг үр дүнд янз бүрийн аргаар хүрч болно” гэсэн эсээний эхлэл хэсгээс үзье.

Хэрэв бид хэн нэгийг гомдоосон бол, цаад хүн өшөөгөө авахын тулд юу ч сэдэж мэднэ. Түүний сэтгэлийг зөөлрүүлэх хамгийн энгийн арга бол үгийг нь дуулгавартай хүлцэн дагаж, өөрийгөө өрөвдүүлэх явдал билээ. Гэвч бүр эсрэгээр, хатуу чанд зоримог эсэргүүцэл үзүүлснээр тааламжтай үр дүнд хүрсэн тохиолдол ч цөөнгүй ээ.

Энд, танд элдэв асуудал бэрхшээл тулгарвал зугтах уу? (хүлцэн дагах уу), сөрөх үү? (зоримог эсэргүүцэх үү) гэдэг асуудлыг дэвшүүлээд бичээч бээр сөрөх нь (зугтахаас угт) зөв бөгөөд ингэснээр ялалтад хүрсэн тохиолдол олон буй хэмээн баримтууд дэлгэжээ.

Уэльсийн хунтайж, манай Гиень мужийг эрхшээлдээ тэгтлээ удаан барьж байсан мөнөөхөн Эдуард өөрийг нь маш хүчтэй эсэргүүцсэн нэгэн хотыг түрэмгийлэн эзэлж авмагцаа, өршөөл хүссэн олон ард, хөлд нь сөхөрсөн эмэгтэйчүүд хүүхдүүдийн орь дуу тавихыг ч үл хайхран толгой дараалан хядах зарлиг гаргажээ. Ийн зарлигдмагцаа хунтайж хотын бүр гүн рүү нэвтрэн ортол ялагсдын өөдөөс аймшиггүй зоригтой тулалдан, довтолгоон бүрийг тогтоон хааж буй гурван франц тайжтай тулгарчээ. Энэ баатарлаг явдлыг нүдээр үзээд гайхаж биширсэн түүний уур хилэнг хүндэтгэх сэтгэл нь хийсгээж орхисон байна. Ингээд сайх гурваас эхлээд хотын бүх иргэнийг өршөөсөн гэдэг.*

*Эпирийн захирагч Искаандрбэг** цэргүүдийнхээ нэгийг хороохоор занаж л дээ. Нөгөө цэрэг нь өршөөл аврал хайж удтал царайчилсны эцэст арга буюу өөдөөс нь сэлэм барин босчээ. Энэхүү шийдэмгий байдал нь захирагчийн хилэнг мохоосон бөгөөд мань цэрэг ч амь насаа нэр төртэйгөөр аварч гарсан гэдэг. Искаандрбэгийн ер бусын бял тэнхээ, эрэлхэг зоригийн тухай олж уншаагүй хүмүүс бол эл жишээг эрс өөрөөр ойлгож магадгүй.*

*Эзэн хаан III Конрад * Баваарын херцог Вельфийн бэхлэлтийг бүсэлж аваад, бүслэгдэгсэд хамгийн ичгүүрт доромжлолыг ч хүлээж авахад бэлэн байсаар атал өршөөх тухай бодохыг ч хүссэнгүй. Гагцхүү, херцогийн хамтаар хотод бүслэгдчихээд буй сурвалжит хатагтай нарт л тэндээс өргөж даах зүйлсээ аваад явган гарахыг зөвшөөрсөн байна. Тэгмэгц хатагтай нар эл уудам сэтгэлд талархаад, эр нөхрүүдээ, хүүхдүүдээ, мөн херцогийг үүрч бүслэлтээс гарахаар шийджээ. Тэдний энэ ариун шударга, зоримог алхам сэтгэлийг нь хөдөлгөсөн тул эзэн хаан догдолсондоо уйлж, ялагдсан херцогт яс махнаасаа дайсагнан өширхөхийг огоорсон бөгөөд энэ үеэс хойш Вельф болон түүний ойр шадар хүмүүст хавьгүй хүнлэг хандах болсон гэнэ. (Монтэнь, 2010, хууд. 7)*

Эдгээр гурван баримт ижил агуулгатай бөгөөд эхний баримтад, Уэльсийн хунтайж Эдуард 1330-1376 эзэлж авсан Францын нутгийн иргэдэд хатуу харгис ханддагаараа алдартай байжээ. Тэрээр Францын Баруун өмнөд муж Гиенийг эзлээд өршөөл хүссэн иргэдийг алж хядах тушаал өгсөн боловч эцсийн хүчээ хүртэл тулалдахаар болсон 3 тайжийн баатарлаг явдлыг үзээд л гайхан биширч бүх хүмүүсийн амийг өршөөсөн тухай өгүүлжээ. Уг баримтуудаар өөрийнхөө элдэв асуудал бэрхшээл тулгарвал сөрөх нь зөв гэсэн санаагаа нотолж баталсан байна.

Монтений эсээ болгонд гарч буй Вергилий, Плиний, Овидий, Сенека, Теренций зэрэг эртний Ромын яруу найрагчдын шүлгийн мөрүүд ишлэл үгс бол мөн л баримт болно.

Зөвхөн эсээ гэлтгүй бүх л төрлийн бичвэрт баримт мэдээлэл чухал байр суурь эзэлнэ. Орчин үеийн техник технологи хөгжсөн үед, баримт мэдээллийг хаанаас яаж авах, мэдээллийн үнэн мөнийг хэрхэн тогтоох асуудал чухал байна.

Баримт мэдээлэл цуглуулдаг олон арга байдаг ч өнөөдөр эсээ нийтлэл бичиж буй оюутан суралцагчид баримт мэдээлэл цуглуулахдаа ихэвчлэн “бэлэн зүйл”, [google.com](https://www.google.com) мэтийн хайлтын программуудыг ашиглаж байна. Тэр ч атугай хиймэл оюунаар бүтээгдсэн ChatGPT зэрэг платформуудаас мэдэхгүй зүйлээ шууд асууж, эсээ хүртэл бичүүлж, тоо бодлогоо бодуулах боллоо.

Хэдийгээр техник технологийн хөгжил дэвшлийг ашиглах нь зүй ёсны боловч бусдын анхаарлыг татах зүйл бичихийг хүсэж буй аваас аль болох өөрөө шууд эрэл хайгуул хийж, шинэ баримт материалын цуглуулах ёстой.

Бичих гэж байгаа сэдэвтэйгээ холбогдсон мэдээллийг аялал жуулчлалаар явах, музей үзвэр үзэх, амталж үнэрлэх, идэж уух, барьж ажиглах зэргээр олж аваад түүнийгээ эсэндээ ашиглах нь илүү итгэл үнэмшилтэй, үнэ цэнтэй болдог. Үүнийг шууд ажиглалтын арга гэнэ. Бичих сэдвийнхээ талаарх мэдээллийг хүмүүсийн туршлага, яриаг сонсох, ном зохиол, бичиг баримт зэргээр дэм олж авбал шууд бус ажиглалтын арга болно. (Ц.Өнөрбаян, 2007)

Баримт материалаа цуглуулсны дараа түүнийг боловсруулах, цэгцлэх ажил тулгарна.

Онлайн эрдэм шинжилгээний бичвэрийн алдартай программ Essayjack-ийг үндэслэгч, судлаач Линди Ледоховси сонгосон сэдвээ сайтар судалж, баримт материалаа өөрөө цуглуулахын чухал болохыг онцолсон.

Жишээ нь: Нэг оюутан Гадаадын Хөрөнгө Оруулалтын хуулийг дэмжих үү, үгүй юү? сэдвээр эсээ бичиж буй тохиолдолд багшийнхаа тусламжтайгаар хамт суралцагч оюутнуудаасаа энэ талаар бичил судалгаа авч болно.

Үг сонгох

Бид өнөө хүртэл “Үг сонголт бол найруулгын амин сүнс”, “Зарим эрдэмтэн судлаачид найруулга зүйн шинжлэх ухаан нь угтаа ойролцоо утгат үгийг сонгон найруулах тухай судалдаг гэж бичсэн байдаг. Найруулга зүй нь хэлэн дэх янз бүрийн ойлголт хийгээд хүний санаа бодлыг оновчтой, товч, тодорхой илтгэх арга замыг тодруулдаг болохоор ойролцоо утгатай үг хэллэгийн найруулгын үүргийг онцлон анхаарч, хамгийн оновчтойг олж сонгохыг чухалчилдаг” (Д.Отгонсүрэн, 1975, хууд. 72) хэмээн бичсээр ирсэн.

Орчин үед үг сонголтын тухай ярихын өмнө тухайн эхийг хэнд зориулж бичих вэ буюу Уншигчдаа тооцох /identify your audience/ гэдэг чухал асуудал тулгарч байна.

Манайд эх зохиож, зохиолгож ирсэн байдлыг ажиглахад, ерөнхийдөө үгийг найруулж, утгыг урлах эртний дорно дахины уламжлал болон XX зууны 1950-аад оноос Орос Зөвлөлтөөр дамжин орж ирсэн өрнө дахины /Stylistique/ гэдэг ойлголтын хүрээнд мэргэжлийн эх зохиогч, бичээч, зохиолч бэлтгэх хандлагатай явж иржээ. Энэ нь нийгэм цаг үеийн байдал, бүх нийтийн боловсрол, бичиг үсэг тайлагдалт зэрэгтэй холбоотой байсан юм.

Тэгвэл өнөөгийн бүх нийтээр бичиг үсэг тайлагдсан, шинжлэх ухаан технологи өндөр хөгжсөн, цахимжсан, нийгмийн сүлжээ, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх талбарууд олноор буй болсон үед хүн бүрд цаг ямагт бичих хэрэгцээ, бичих ур чадвараа хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарах боллоо.

Иймд бичгийн хүмүүс, мэргэжлийн зохиолчдын болон бүх нийтийн бичих чадвар, тэдгээрт тавих шаардлагыг ялгаж салгаж ойлгох ёстой болж байна. Бүгд зохиолч, яруу найрагч болохгүй тул бүгд уран, сайхан бичих албагүй. Харин бүгд бичих чадварыг эзэмших ёстой.

Манай судалгаанд хамрагдсан оюутнууд төрөл бүрийн мэргэжлээр сурч байгаа бөгөөд бүгд зохиолч сэтгүүлч болохгүй тул тэдний ерөнхий бичих чадварыг дээшлүүлэх тухай асуудлыг энд хөндөж байна.

Тэдний эх зохион найруулж бичихдээ гаргаж буй дараагийн нийтлэг дутагдал бол хэрэгтэй хэрэггүй, элдэв янзын чамин ганган үг сонгон хэрэглэх явдал юм. Мэдээж хэрэг, энэ нь оюутнуудын буруу биш бөгөөд манай нийгэм, боловсролын тогтолцоо, сургалтын арга хэлбэртэй холбоотой.

Өмнө манайд хэн уран, сайхан үг сонгож, уянгалж хэлбэрдэж бичсэн бичвэрийг сайн бичвэрт тооцдог байсан бол одоо асуудлаа зөв тодорхойлж, эерэг сөрөг аргумент дэвшүүлж, нотолж баталж, эсвэл үгүйсгэж, дүгнэсэн илүү дутуу гоё чамирхсан үг хэллэггүй бичвэрийг чухалчлах болжээ. Тухайлбал:

АНУ-ын алдартай зохиолч Жон Гришам “Бидний мэддэг үг, мэдэх ёстой үг, хэн ч мэдэхгүй үгс гэсэн гурван төрлийн үг байдаг бөгөөд та зохиолч яруу найрагч болох гээгүй бол хамгийн сайн мэддэг үгээ л сонго (Grisham, 2017) гэжээ.

Түүнийхээр, үгийн баялаг арвинтай байх нь мэдээж хэрэг чухал боловч

Танд төрсөн өдрийн мэнд хүргэе/Төрсөн өдрийн мэнд хүргэе

Танд эснэсэн өдрийн мэнд хүргэе/ Эснэсэн өдрийн мэнд хүргэе...

гэх жишээний хоёр дахь тохиолдлын тухайд таны хэлэх зүйл бусдад нөлөөлөх бус эсрэгээрээ ойлгомжгүй, хий чамирхал, хоосон гайхуулал төдий болно.

Мөн энэ талаар доктор Д.Сэрдарам “Оюутан бас эсээ” нийтлэлдээ өнөөгийн оюутнуудын эсээ бичихэд саад болж буй дөрвөн зүйл байна. Үүнд:

- Хуулбарлах сэтгэлгээ
- Уран гоё үг
- Хоосон цэцэрхэл

Элдэв афоризм, дөрвөн мөртүүд (Д.Сэрдарам, 2014) хэмээн маш оновчтой тодорхойлсон байдаг.

Мөн тэрээр “Хуулбарлах сэтгэлгээгээ авч хая. Гоогле-ээр ямар нэг юм хайхад тэр нь олон сайтуудад хуулагдсан байдаг. Монголчуудын сэтгэлгээний цар

хүрээг энэ зан хумиад байна” (Д.Сэрдарам, Оюутан ба эсээ, 2014) гэж өнөөгийн оюутны бичих чадвараа хөгжүүлэх гэхээс илүү бэлэн юм хуулж авч ирж дүн авах төдийхнөөр сэтгэж буй үнэн мөнийг илэрхийлжээ.

Манай оюутнуудын хувьд ч асуудлаа ончтой тодорхойлж чадахгүй улмаас бэлэн бичвэрүүд энд тэндээс хуулж, тасалж нийлүүлж “эвлүүлэх” хандлага түгээмэл ажиглагдаж байна.

Энэ сэтгэлгээг өөрчлөөгүй цагт бичих чадвар эзэмших тухай яриа дэмий хоосон зүйл болно.

Дүгнэлт

Өнгөрсөн хугацаанд, бид хүний бичсэн зүйл /Product writing/-ийг судлахад гол анхаарлаа хандуулж, бичих үйл явц /Process writing/ болон хүн аливаа зүйлийг бичихэд сэтгэц танин мэдэхүйн ямар үйл ажиллагаа явагддаг талаас бага судалж, энэ талын мэдлэг, чадварыг оюутан суралцагчдад бага эзэмшүүлжээ. Мөн оюутан суралцагчдад бичих ур чадварыг олгохдоо бүгдийг бичгийн хүмүүс /эрдэмтэн судлаачид/, зохиолч болгох шаардлага тавьж, бас хүний бичсэн зүйлийг /text/ задлах, алдаа мэдгийг засуулахад түлхүү анхаарч ирснээс өөрийг нь алдаатай ч хамаагүй бичүүлж сургах бүтээлч үйл ажиллагааг орхигдуулж иржээ. Энэ мэтчилэн алдаа дутагдлуудаа засах хэрэгтэй байна. Багш нар орчин үеийн онол, судалгаатай танилцаж, энэ талын мэдлэг чадвараа дээшлүүлж, заах арга барилаа өөрчлөх ёстой. Ингэснээр, “нэг юм” бичиж дүн оноо авах гэсэн биш “би бичих чадвар эзэмших ёстой”, “бичих чадвартай болох нь надад маш чухал” гэсэн чин сэтгэл, үзэл хандлагатай оюутан суралцагчийг буй болгох нь бидний нэн тэргүүний зорилго болоод байна.

Ном зүй

- Айжан, З. (1997). *Л.Түдэвийн эссе, түүний онцлог, ур чадвар*. Улаанбаатар хот.
- Батжаргал, Д нар. (2015). *Илтгэх урлагийн онол, арга зүй*. Улаанбаатар: МУИС пресс
- Батхуяг, П. (2018). *Эсрэг хурд буюу эсээний тухай эсээ*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс
- Бямбадорж, Б. (2014). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: БитПресс
- Дэлгэрэхцэцэг, Ц. (2008). Япон хэлээр найруулан бичих чадвар дээшлүүлэх онол арга зүйн асуудал. *Докторын судалгааны ажил*. Улаанбаатар: Монгол улсын их сургууль.
- Жавзанпагма, З. (2019). *Оюутны эсээ бичих чадварыг хөгжүүлэх нь*. Улаанбаатар.
- Мишэль дө Монтэнь. (2010). Сонгомол эсээнүүд. Улаанбаатар: Мөнхийн үсэг принт
- Отгонсүрэн, Д. (1975). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: Д.Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинат
- Оюумаа, Д. (2020, 1 2). *Бага ангийн сурагчдын зохион найруулан бичих чадварыг хөгжүүлэх арга зүй*. Retrieved from Боловсролын ерөнхий газар.
- Сүхбаатар, Ц. (1993). *Найруулан бичих арга ухаан*. Улаанбаатар: ШУ-ы хэвлэлийн “Эрдэм” компани.
- Сүхбаатар, Ц. (2007). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: Удам Соёл хэвлэлийн газар.
- Эрдэнэсан, Д. (2021). *Монгол хэл заах арга*. Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.
- Grisham, J. (2017). *Writing Advice from John Grisham*. Retrieved from publicationcoach.com.
- Ledohowski, L. (2023). *How to Pick the Right Persuasive Essay Topic*. Retrieved from wizeprep.com.
- Shewan, D. (2023). *16 Easy ways to improve your writing skills*. Retrieved from worldstream.com.
- Buffon. (1999). *Discours sur le style*. www.britanica.com: <https://www.britannica.com/topic/Discours-sur-le-style/>

American Press Institute. (2010). *Make Sentences Shorter*. <https://prsay.prsa.org/>: <https://prsay.prsa.org/2009/01/14/how-to-make-your-copy-more-readable-make-sentences-shorter/>
Journalbuddies (2022). *162 Creative writing topics and ideas*. www.journalbuddies.com: <https://www.journalbuddies.com/creative-writing-2/creative-writing-ideas-2/>

Abstract

In the article, the author explains what kind of psychological cognitive activities occurs when an individual writes something and it is more pivotal for the students to acquire a knowledge of the process writing rather than analyzing and correcting mistakes in the product writing. Moreover, language teachers should constantly familiarize themselves with the theory, research, requirements, and recommendations regarding contemporary writing skills, and modify their teaching methods to prepare all students to become writers, scholars, and researchers. Hence, creating an enthusiastic student who believes, “I must acquire the writing ability”, and “It is significant for me to acquire writing skills” and not just getting grades is our top priority. The article suggested that if students have this attitude all of them can acquire successfully writing skills.